

**Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд банк,
санхүүгийн байгууллагын оролцоо түүний
эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа**

**A Comparative Study of the Participation of Banks
and Financial Institutions in Combating Money
Laundering and its Legal Regulation**

Жаргалсайханы Уясах

Хууль зүйн ухааны бакалавр (LL.B.)

Улаанбаатар хот, Монгол Улс.

j.uyasakh@gmail.com

© J.Uyasakh, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Сүүлийн жилүүдэд мөнгө угаах гэмт хэргийн төлөв байдал, шинж, хувьсаж, энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх арга нарийсч байгаа нь олон улсын эдийн засаг, банк, санхүү, бизнесийн зэрэг нийгмийн бүхий л салбарт сөргөөр нөлөөлж байгаа тул дэлхий нийтээр мөнгө угаахтай тэмцэх нэг стандартыг бэхжүүлэхээр олон улсын болон бүс нутгийн байгууллагаас гадна үндэсний хэмжээнд эрх бүхий байгууллагууд хамтран идэвхтэй үйл ажиллагааг хэрэгжүүлсээр байна.

Санхүүгийн байгууллагын санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж буй үйлчилгээний нөхцөл байдлаас шалтгаалан мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл нэмэгддэг бөгөөд түүн дотроо банк бус санхүүгийн байгууллага нь тооны хувьд олон, газар зүйн байршлын хувьд өргөн тархсан тул мөнгө угаах эрсдэл нь банкны бус сектор дахь бусад санхүүгийн байгууллагуудтай харьцуулахад илүү өндөр байх тул мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд банк болон банк бус санхүүгийн байгууллагын оролцоо, тэдгээрийн уялдаа холбоо бүхий эрх зүйн зохицуулалтыг цаашдын олон улсын чиг хандлагад нийцүүлэх, боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход оршино.

[Түлхүүр үг]

Мөнгө угаах, суурь гэмт хэрэг, олон улсын жишиг, олон улсын эрх зүйн тогтолцоо, үндэсний эрх зүйн тогтолцоо, банк, банк бус санхүүгийн байгууллага, эрсдэлийн үнэлгээ, сэжигтэй гүйлгээ, үйлчлүүлэгчээ таньж мэдэх, хяналтын ажиллагаа, тогтмол сургалт, хиймэл оюун ухаан, машин сургалт, шинэ технологи.

I. Оршил

Орчин үед техник, технологийн дэвшил илүү ухаалаг түвшинд хүрч, нийгмийн харилцаанд оролцож буй хэн бүрт шинэ боломжийг бий болгож байгаа ч, үүнийг дагаад гэмт хэргийг үйлдэхдээ зохион байгуулалт, арга техникийн хувьд улам нарийсаж, улмаар түүнийг илрүүлэх, тэмцэх ажиллагаанд ихээхэн хүндрэлийг бий болгож байна. Эдгээр гэмт хэрэгт яах аргагүй мөнгө угаах гэмт хэрэг багтдаг. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх талаар олон улсын хэмжээнд хамтын ажиллагаа хэрэгжээд хагас зуун жил болсон ч олон улсын эрх зүйн зохицуулалтыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа байдал дутмаг, үндэсний хэмжээний эрх бүхий байгууллагуудын чадавх сул, эрх зүйн зохицуулалт сул байх нь үүний үр нөлөөг сулруулж байна.

Мөнгө угаахын эсрэг зохицуулалтыг эрүүгийн хуульд тусгаж, прокурор, цагдаагийн болон авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд гол үүрэг гүйцэтгэдэг хандлага дэлхий нийтэд зонхилж ирсэн. Гэтэл мөнгө угаах үйл ажиллагаа илрүүлэхэд банк болон банк бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүрэг чухал юм. Сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд банкны байгууллагад энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд үүрэг хүлээлгэж, хууль бус үйл ажиллагааг илрүүлэх тогтолцоог үндэсний хэмжээнд нэвтрүүлэх талаар олон улсын хэмжээнд нэлээд анхаарч ирээд байгаа.

Мөнгө угаах гэмт хэрэг нь улс орны тогтворгүй байдал, эдийн засгийн бодлого, хувь хүн, хуулийн этгээд тэр дундаа банк, санхүүгийн байгууллагын салбар сөргөөр нөлөөлдөг. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эд хөрөнгөө оффшор бүсэд байршуулах, нуун дарагдуулах үйл ажиллагаанд улс орнуудын банк, санхүүгийн байгууллага түүний салбар нэгж, ажилтнаар дамжуулан гүйцдүүлэх байдал ихсэж байна. Монгол улсад энэ сэдвээр эрүүгийн эрх зүйн хүрээнд прокурор, цагдаагийн болон авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд ямар үүрэгтэй, холбогдох хуулийн зохицуулалт нь ямар байх талаар зохицуулсан байдаг бол банкны салбарын холбогдох зохицуулалтын талаар судалгааны ажил төдийлөн хийгдээгүй байна. Иймд мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, түүнтэй тэмцэхэд банк, санхүүгийн байгууллагын оролцоо ихээхэн чухал ач холбогдолтой байхын учир холбогдол, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг судлан цаашдын чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлэх нь зүйтэй.

II. Үндсэн хэсэг

Мөнгө угаах гэмт хэргийн эсрэг олон улсын үзэл баримтлалт, зохицуулалт, чиг хандлага

А. Олон улсын үзэл баримтлал, мөнгө угаахтай тэмцэх олон улсын байгууллага

Олон улсын эрх зүйн хэм хэмжээг улс орнууд тогтоож бий болгодог гэж ихэнх судлаачид үздэг бөгөөд энэ нь ч дийлэнх тохиолдолд үнэн байдаг. Улс бүр бүрэн эрхтэй, тусгаар тогтносон учраас тэдгээрийг захирах дээд эрх хэмжээний байгууллага, захиргаа байхгүй бөгөөд эдгээр улс нь харилцан зөвшилцлийн үндсэн дээр өөрсдийн дагаж мөрдөх хэм хэмжээг тогтооно гэсэн үг юм.¹ Иймд улс бүр өөрсдийн үндэснийхээ эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлж, тогтоож мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа боловч энэ төрлийн гэмт хэргийн онцлог, шинж хийгээд түүнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд дан ганц өөрийн улсын хэмжээнд тэмцээд үр дүнгүй. Учир нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаанаас гадна үндэсний эрх зүйн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, тэдгээрээс сайн туршлагыг авч хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Үндэсний хууль тогтоомжид харийтахаас гадна улс орны хоорондын хэв ёсны харилцааг хөндөн, хамтын ажиллагаанд ямар нэгэн хэмжээгээр хор хохирол учруулдаг гэмт үйлдлийг олон улсын шинжтэй гэмт хэрэг гэж тодорхойлох бөгөөд улс орнууд хоорондоо гэрээ хэлэлцээр байгуулах, олон талт гэрээ конвенцийн заалтуудыг үндэснийхээ хууль тогтоомжид тусгах замаар уг төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэг.²

Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт нь дэлхий нийтэд нэгэн зэрэг гэнэт бий болоогүй бөгөөд хууль бусаар олсон орлого, хөрөнгөө хэрхэн хууль ёсны болгож “өөртөө хэрхэн хэрэглэж, ашиглах вэ?” гэх гэмт хэрэг үйлдэгчийн бодол, аргаас үүдэлтэй бөгөөд энэ гэмт хэргийн ойлголтыг судлахдаа судлаачид дараах хоёр түвшинд судлан авч үзсэн байна.

1. Энэ гэмт хэрэг дэлхийн улсуудад хэзээ анх үүссэн талаар,³
2. Мөнгө угаах гэмт хэргийг улс орнууд үндэсний эрх зүйн

¹ Ян Клабберс, МУИС-ийн ХЗС. Уянга.М, Туулайхүү.Э (Орчуулгын бүтээл) “Олон Улсын эрх зүй” УБ., 2022, 28 дахь тал

² ХЗДХЯ, “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл, “Олон улсын нийтийн эрх зүй” гарын авлага, УБ., 2007, 107 дахь тал

³ АТГ, Дуламсүрэн.Д, Галбадрах.С “Мөнгө угаах гэмт хэрэг” гарын авлага, УБ., 2020, 7 дахь тал

тогтолцоонд⁴ анх хэрхэн хуульчилсан түүний түүний өөрчлөлт, шинэчлэлтээр олон улсын байгууллагын зөвлөмжийг хэрхэн тусгасан байдал, зарим гадаад орны мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг судлан боловсронгуй болгож буй ойлголтын талаар судлах нь зүйтэй юм.

Мөнгө угаах гэмт хэрэг нь анх Америкийн Нэгдсэн Улсын “Их хямрал”-ын үе буюу 1920-иод онд Америкийн маф (зохион байгуулалттай гэмт бүлэглэл)-ийг Аль Капоне нь удирдан зохион байгуулж, түүний бүлэглэлийн гишүүд Чикаго хотод архины наймаа, мөрийтэй тоглоомын гэмт хэрэг үйлдэж олсон бэлэн мөнгийг хууль ёсны болгохын тулд олон угаалгын газрыг худалдан авч сүлжээ хэлбэрээр ажиллуулж эхэлсэн гэж судлаачид тэмдэглэсэн байдаг. Улмаар олон тооны үйлчлүүлэгчидтэй жижиг байгууллагуудын орлогыг хянах нь маш хэцүү учраас тэд хууль бусаар олсон их хэмжээний бэлэн мөнгийг ажил үйлчилгээнээс олсон мэт болгож хувиргадаг байсныг “1928 онд АНУ-д L`expresse сонин сэтгүүлчид “Хувцас биш мөнгө угааж байна” гэх гарчиг бүхий нийтлэлийг олон нийтэд мэдээлснээр мөнгө угаах (money laundering) гэсэн нэр томъёо гарсан байна.”⁵ Тухайн үед мөнгө угаах гэмт хэргийн талаар тодорхойлон хуульчилаагүй ч энэ төрлийн орлогыг хураан авах, үйл ажиллагааг нь таслан зогсоох үндсэн буюу суурь гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэж иржээ.

Улмаар Америкийн Нэгдсэн Улсын засгийн газраас энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тодорхой арга хэмжээ авахаар 1970 онд Конгресс “Банкны нууцын тухай хууль”-г баталснаар мөнгө угаахтай тэмцэх анхны хууль болгон баталсан.⁶

Энэ үеэс мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд түүнтэй тэмцэх андагч суурь нь банк, банк санхүүгийн бусад байгууллага түүний салбар нэгж, ажилчдыг үүрэгжүүлэх, тэдний туслалцааг авах нь зүйтэй гэж үзсний илрэл юм. Тухайн үед “Банкны нууцын тухай” хуулиар дараах шаардлагыг тодорхойлон хуульчилсан байна. Үүнд:

- Банкууд валютын гүйлгээний тайланг ашиглан 10,000 доллараас дээш мөнгөн гүйлгээг тайлагнах

- Гүйлгээ хийж буй хүмүүсийг зөв тодорхойлох

- Санхүүгийн гүйлгээний зохих бүртгэлийг хөтөлж байх гэж заасан⁷ нь АНУ-ын нутаг дэвсгэрт зөөвөрлөж, шилжүүлсэн, эсвэл

⁴ Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн шийдвэрийн судалгаа” цуврал 16, УБ., 2024. 19-23 дахь тал

⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнтэй тэмцэх асуудал” УБ., 2013

⁶ <https://www.irs.gov/businesses/small-businesses-self-employed/bank-secrecy-act>

⁷ Bank Secrecy Act (1970), <https://www.irs.gov/businesses/small-businesses->

санхүүгийн байгууллагад хадгалуулсан валют болон бусад мөнгөний хэрэгслийн эх үүсвэр, хэмжээ, хөдөлгөөнийг тодорхойлоход туслах зорилготой гэж үзжээ.

Үүнээс үзэхэд мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд, түүнтэй тэмцэхэд банк болон санхүүгийн бусад байгууллагын хяналтыг сайжруулах, энэ төрлийн гэмт хэргийг шалгах эрх бүхий байгууллагаас хамтран ажиллах тэдгээр хоорондын уялдаа холбоог эрх зүйн зохицуулалтаар боловсронгуй болгох нь зүйтэй юм. Түүнчлэн АНУ-н засгийн газраас энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоохын тулд 1986 онд анх удаа “Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль”⁸-ийг баталж мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцон хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр тогтоосон байна.

1989 оны 07 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсын нийслэл Парис хотноо аж үйлдвэрийн томоохон долоон орны төр, засгийн тэргүүн, Европын хамтын нийгэмлэгийн комисс (The European Communities /EC/-ын ерөнхийлөгч, бусад найман улсыг багтаасан эдийн засгийн дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулсан бөгөөд хурлын шийдвэрээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг судлах, боловсруулах зорилгоор “Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/” (Financial Action Task Force /FATF/-ыг байгуулсан.⁹ ФАТФ нь дэлхийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн хууль бус үйлдлүүд, нийгэмд учруулж буй хор уршгаас урьдчилан сэргийлэх зорилготой олон улсын стандартыг тогтоохоор ажиллаж байна. ФАТФ нь мөнгө угаах арга техник, чиг хандлагыг судалж, үндэсний болон олон улсын түвшинд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хянаж, мөнгө угаахтай тэмцэхэд шаардлагатай арга хэмжээг тодорхойлох үүрэг хүлээсэн бөгөөд 1990 оны 4-р сард ФАТФ байгуулагдсанаас хойш жил хүрэхгүй хугацаанд Дочин зөвлөмжийг багтаасан тайлан гаргажээ. Эдгээр нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны цогц төлөвлөгөө гаргах зорилготой байв.

1997 оны 2 дугаар сард Тайландын Бангкок хотод ФАТФ-ын салбар байгууллага болох “Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг /АНДМУТБ/” (Asia / Pacific Group on Money Laundering /APG/-ийг байгуулсан.¹⁰ АНДМУТБ нь бүс нутгийн улс орнуудтай хамтран ажиллаж, мөнгө угаахтай тэмцэх бодлого, санаачилгыг

self-employed/bank-secrecy-act (сүүлд үзсэн 2025.02.16)

⁸ History of Anti-Money Laundering Laws, Money Laundering Control act (1986), <https://www.fincen.gov/history-anti-money-laundering-laws> (сүүлд үзсэн 2025.02.16)

⁹ Financial Action Task Force /FATF/ web site, <https://www.fatf-gafi.org/en/the-fatf/history-of-the-fatf.html>

¹⁰ (Asia / Pacific Group On Money Laundering /APG/) web site, <https://apgml.org/>

хэрэгжүүлэх бүс нутгийн үүрэг амлалтыг бий болгож, бүс нутгийн хамтын нийгэмлэгийн байнгын ажиллагаатай байгууллага юм.

Б. Олон улсын эрх зүйн зохицуулалт, хандлага

Мөнгө угаах гэмт хэрэг нь эдийн засгийн хувьд тогтворгүй, ядуу буурай, эсвэл жижиг эдийн засагтай гадны зээл, буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтад тулгуурлан хөгжиж буй орон, мөн гадаадын хөрөнгө оруулагчдын мөнгөний эх үүсвэрийг шалгах боломж муутай банк, санхүүгийн эрх зүйн зохицуулалт болон энэ салбарт хяналт сул улс орнуудыг түшиглэн үйлдэгдэх нь түгээмэл байдаг.¹¹

Мөнгө угаах гэмт хэрэг нь үндэсний болон олон улсын түвшинд үйлдэж байгаа ч олон улсын түвшинд үйлдэгдэж байгаа нь илүү их хэмжээний хөрөнгө, мөнгө, орлого эргэлддэг тул эдийн засгийн хувьд хохиролтой мөн түүнийг илрүүлэхэд цаг хугацаа, хүндрэл бэрхшээл цөөнгүй гарч байна. Олон улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор улс орнууд зохих шийдвэр, олон улсын гэрээ, конвенцыг хамтран баталж, дагаж мөрдөж байна. Тухайлбал 1988 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэх НҮБ-ын конвенц, 1999 онд Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх конвенц, 2000 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1267, 1373 дугаар тогтоол, 2003 онд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг тус тус байгуулсан.

ФАТФ нь дээр дурдсанчлан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүний улмаас нийгэмд учруулж буй хор уршгаас урьдчилан сэргийлэх зорилготой олон улсын стандартыг тогтоохоос гадна НҮБ-ын конвенц, тогтоолуудыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм. Уг байгууллагаас “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 зөвлөмж”¹² нэртэй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг улс, орон бүрд нэг түвшинд хүргэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд улс хоорондын хамтын ажиллагаанд учирч болох хүндрэлүүдийг даван туулах зорилготой баримт бичгийг гаргасан. Энэ зөвлөмжийн хүрээнд улс орнууд өөрсдийн үндэсний бодлогыг боловсруулах, эрх зүйн тогтолцоондоо өөрчлөлт оруулах замаар сайжруулж байгаа ч зарим улс орнууд өөрсдийн онцлогт тохируулан суурь гэмт хэргийг тодорхойлох нь чухал юм.

¹¹ Монгол Улсын төв банк “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны сургалтын гарын авлага”. УБ., 2018, (19 дэх тал)

¹² International standards on combating money laundering and The financing of terrorism & proliferation (The fatf recommendations), 2012-2025, <https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/recommendations/FATF%20Recommendations%202012.pdf.coredownload.inline.pdf>

Мөнгө угаах гэмт хэргийн үндэсний эрх зүйн зохицуулалт түүний өөрчлөлт, шинэчлэлт, түүний хэрэгжилт, үр дүн:

А.Үндэсний эрх зүйн зохицуулалт, түүний өөрчлөлт, шинэчлэл

Монгол Улсын хувьд 1993 оноос энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн шинжийг гэмт хэрэгт тооцож, Эрүүгийн хуульд хуульчилсан хэдий ч “Мөнгө угаах” гэмт хэрэг томьёоллоор анх 2002 оны Эрүүгийн хуулиар зохицуулсан байна.

Монгол Улс 2001 оноос эхлэн үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд анхаарч, судлан олон улсын байгууллагуудаас гаргасан конвенц, зөвлөмжийг хүлээн авч үндэсний эрх зүйн тогтолцоондоо тусгасан байна. Үүний үр дүнд 1999 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн “Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай” олон улсын конвенц-д 2003 оны 12 дугаар сарын 13-ны өдөр нэгдэн орж¹³, 2004 онд ФАТФ (FATF)-ын салбар байгууллага болох “Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллага APG/-ын гишүүн орон болсноор¹⁴ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартуудыг мөрдөн ажиллах үүрэг хүлээсэн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхээс гадна гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэх ажлыг үндэсний хэмжээнд тасралтгүй зохион байгуулсаар ирсэн боловч өөрийн улсын нийгэм, эдийн засгийн болон бусад онцлог шинжийг харгалзан боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байсаар байна.

Тухайлбал, 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлд “Хууль бусаар олж авсан хөрөнгө, мөнгө ашиглах” гэмт хэргийг хуульчилсан бол 2006 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай бие даасан хуулийг батлан мөрдүүлсэн нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, түүнтэй тэмцэх чиглэлд чухал алхам болсон.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч,

¹³ Төрийн мэдээлэл тусгай дугаар 2006 он

¹⁴ <https://fiu.mongolbank.mn/mn/p/3300>

эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”¹⁵ гэж шинээр найруулан хуульчилсан байна. Өмнөх гэмт хэргийн зохицуулалттай агуулгын хувьд харьцуулахад гурван өөр обьектив шинжийг зааж, тэдгээрийн аль нэгийг хангасан байхад мөнгө угаах гэмт хэрэг болохоор заасантай нэгэн адил байна. Харин “Энэ төрлийн гэмт хэргээр зүйлчлэхэд ямар төрлийн гэмт хэрэг үйлдэж хууль ёсны эргэлтэд оруулсан эсэх нь зүйлчлэлд нөлөөлөхгүй”¹⁶ гэж тодорхойлсон нь суурь гэмт хэргийн талаар тодорхой зааж өгөөгүйгээс ахуйн хүрээний хийгээд бүхий л гэмт хэргийг хамруулахаар байна.

Иймд дагаж мөрдөх олон улсын эрх зүйн хэм хэмжээ, бусад улсын хуульчилсан байдал түүний сайн туршлагыг харьцуулахаас гадна дотоодын түүхэн уламжлалыг судалж, одоогийн нийгмийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан суурь гэмт хэргийг оновтой тодорхойлох шаардлагатай байна.

Мөнгө угаах гэмт хэргийн практик хэрэгжилт, түүний үр дүн:

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) болон түүний бүс нутгийн байгууллагууд өөрийн гишүүн орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог зөвлөж (40 Зөвлөмж), 11 Шууд хэрэгжилтийн шаардлагын дагуу 2007, 2017 онуудад харилцан үнэлгээг хийсэн ба Монгол Улсын хүсэлтийн дагуу 2017 онд хийсэн харилцан үнэлгээний техникийн хэрэгжилтийн байдалд 2019 онд дахин үнэлгээ хийсэн байна.

2017 онд Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хийсэн харилцан үнэлгээгээр 40 зөвлөмжөөс 20 нь хангалтгүй, шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлт бүхэлдээ хангалтгүй байсан нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, түүнтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтад орох эрсдэлтэй байгаа тул 40 зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар хугацаатай шаардлага буюу үүрэг даалгавар өгсөн. Энэ ажлын хүрээнд үнэлгээгээ сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч, бүс нутгийн болон олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилласан боловч ФАТФ-аас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр “Монгол Улсыг стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад оруулж”¹⁷, цаашид авч

¹⁵ Эрүүгийн хууль. 2017 он, 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, <https://legalinfo.mn/mn/detail/11634>

¹⁶ Мөн тэнд. 207 дахь тал


¹⁷ Монгол банк, 2019 оны жилийн тайлан, <https://www.mongolbank.mn/file/2bcdfeb67fe28d76b0870e1b4fbb5c1/files/2019.pdf>

хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг өгсөн байна. Өөрөөр хэлбэл “Саарал жагсаалт”-д оруулсан энэ юм. Энэхүү жагсаалтад орсноор банкууд корреспондент харилцаагаа алдах, гадаад төлбөр тооцоо, олон улсын мөнгөн гуйвуулга удаашрах, зардал нэмэгдэх, олон улсад харилцаанд Монгол Улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлж, гадаадын хөрөнгө оруулалт буурах зэрэг эрсдэл бий болсон.

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт”-аас гарахын тулд 2021 оны 05 дугаар сар хүртэл авч хэрэгжүүлэх ФАТФ-аас өгөгдсөн 4 чиглэл бүхий 6 үүрэг даалгаврыг биелүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж улмаар ФАТФ-ын ерөнхийлөгч 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсыг “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт”-аас албан ёсоор хассан талаар зарласан. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлангаас үзвэл Монгол Улсад авлига, албан тушаалын гэмт хэрэг, кибер орчинд хууль бусаар халдах зэрэг гэмт хэргээс мөнгө угаагдах эрсдэл өндөр байгаа бөгөөд ахуйн хүрээнд үйлдэгддэг хулгайлах, дээрэмдэх зэрэг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон хууль бусаар ан агнах, мод бэлтгэх зэрэг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргүүд эрсдэлийн түвшин бага, дунд байгаа нь судалгаагаар тогтоогдсон байна.

Гэмт хэрэг үйлдсэн эсэх түүнийг гэм буруутайг эцсийн байдлаар шүүхийн байгууллага тогтоодог. Тэгвэл мөнгө угаах гэмт хэргийг Тагнуул, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллагаас чиг үүрэг бүхий нэгж, алба хаагч мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэдий ч үүнээс шүүхээр хэдэн хэргийг шийдвэрлэсэн байдлаар эцсийн үр дүн гарах учиртай.

2020-2024 оны эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах)-ээр шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлтийг харьцуулбал:¹⁸



¹⁸ <https://shuukh.mn/> нэгдсэн цахим сайтаас мэдээллийг авч хийсэн.



График 2. Мөнгө угаах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэсэн байдал (2024 оны тоон үзүүлэлт)

Мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа тоон үзүүлэлт нь өндөр боловч шүүхийн шатанд шийдэгдэж байгаа тоон үзүүлэлт нь харьцангуй бага байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг шалгахад аливаа хүндрэл бэршээл тулгарах, хил дамнан үйлдэгдэх, ээдрээ төвөгтэй байдлаас мөрдөн шалгах ажиллагаа, нотлох ажиллагаа удааширч байгааг үгүйсгэхгүй.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд банкны салбарын зохицуулалт, олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүрэг, хэрэгжилт

А. Банкны салбарын эрх зүйн зохицуулалт

Банкны салбар нь зах зээл дээр эзэлж буй активын дүн, цэвэр ашиг зэргээрээ мөн өндөр байдаг ч үүнийг дагаад мөнгө угаах эрсдэл нэмэгддэг. Мөнгө угаах эрсдэл нь банкны салбар дах хадгаламж, зээл, хөрөнгө оруулалт, гадаад валют зэрэг үйлчилгээгээрээ дамжуулан мөнгө угаагчийн нэгдүгээр түвшний холбоо барих цэг болдог гэж үздэг.¹⁹

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлогыг хууль бус хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах, мөнгөний гарал үүслийг хуулийн дагуу харагдуулахад банк болон санхүүгийн байгууллагын олон дамжлагат шилжүүлгийг ашиглах нь илүү хялбар бөгөөд түргэн шуурхай байдаг тул энэ салбарт анхаарал хандуулах чухал юм. Мөнгө угаах гэмт хэрэгт хамгийн их өртөж болох эрсдэлт салбараар Монгол Улсын хэмжээнд санхүүгийн салбарын дийлэнх их хувийг эзэлж байгаа банкны салбар зүй ёсоор багтах ч хоёрдугаарт банк бус бусад зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн байгууллагууд орж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд банк болон банк бус санхүүгийн байгууллагаас мөнгө угаах гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанд холбогдолтой байж болзошгүй

¹⁹ Yusarina Mat Isa “Money Laundering Risk: From the Bankers’ and Regulators Perspectives”, <https://www.sciencedirect.com/science/article/pii/S2212567115010758>

сэжигтэй гэж үзсэн гүйлгээг мэдээлэх, мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлэх зайлшгүй шаардлагатай гардаг. Үүний дагуу Монгол Улс мөнгө угаах гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий мэргэшсэн байгууллагыг 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Санхүүгийн мэдээллийн алба” (СМА)-ыг Монголбанкны дэргэд байгуулснаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэс, суурийг тавьсан.²⁰

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээллийг мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан, мэдээлэл хүлээн авах, дүн шинжилгээ хийх, энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажилладаг.

Монгол Улсын хүн амын амжиргааны түвшин, бизнесийн салбарын үйл ажиллагааны онцлог, банкны бүтээгдэхүүн үйлчилгээний сул талыг ашиглаж гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөө хэрхэн банканд байршуулж, нуун далдалж байгаа арга, техникийг судалж Хууль сахиулах байгууллага, Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, Монголын банкны холбоо зэрэг байгууллагууд хамтран ажлын хэсэг байгуулж судалгаа шинжилгээ хийсний үндсэн дээр оновчтой дүрмүүдийг шинээр боловсруулж нууцлалын зэрэглэлтэй эрх зүйн акт болгон бүх арилжааны банкууд дагаж мөрдөх шаардлагатай гэж үзэж байна. Нууцын зэрэглэлтэй гэдэг нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх хяналтын механизмын талаар олон нийтэд нээлттэй байх нь ямар ч үр ашиггүй гэж үзэж болно. Учир нь гэмт хэрэг үйлдэгч этгээд баригдахгүй байх туулийн зорилготой тул судалгаа шинжилгээ хийх нь тодорхой юм.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хийхдээ тухайн харилцагчаас эрхэлж буй ажил, бизнесийн болон хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах, боломжийн хэмжээнд эдгээр мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлахаар заасан. Хэрвээ харилцагч таньж мэдэх болон эцсийн өмчлөгчийг тогтоохтой холбоотой мэдээллийг харилцагч гаргаж өгөхөөс татгалзсан тохиолдолд бизнесийн харилцаа үүсгэх, гүйлгээ хийхээс татгалзах, өмнө үүсгэсэн бизнес

²⁰ Санхүүгийн мэдээллийн алба (СМА), 2021 оны үйл ажиллагааны тайлан, 9 дахь тал

харилцааг зогсоох арга хэмжээ авах талаар зохицуулсан. Харилцагч нар банканд дээрх мэдээллийг өгөх хууль, эрх зүйн зохицуулалтыг ойлгохгүй эсхүл мэдээлэл өгөхөөс татгалзах тохиолдол их гардаг боловч журамд заасны дагуу бизнес харилцааг зогсоох буюу дансыг нь хаах арга хэмжээ авдаггүй. Иймд банкууд тус зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэх, зохицуулагч байгууллагын зүгээс харилцагч нарт хууль, журмыг сурталчлах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол Улсад 1 төв банк (Монгол банк), 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Монгол Улсад банк байгуулах, банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авахад Монгол банк “Банкны тухай хууль”-д заасан шалгуур үзүүлэлтийг тогтоож зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх ба мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой дараах шалгуурыг шалгаж тогтоосон байхыг шаарддаг.

1. Банкинд хувь нийлүүлэх мөнгөн хөрөнгө нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан, хууль ёсны үйл ажиллагаанаас бий болсон хөрөнгө болохыг нотлох хангалттай баримт бичиг бүрдүүлсэн эсэх.

2. Банк байгуулах нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай аливаа байдлаар холбоотой эсэх, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх эсэх.

Банк болон банк бус санхүүгийн байгууллагууд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг нь ихэвчлэн сэжигтэй гүйлгээг анхлан илрүүлдэгт байдаг. “Харилцагчийг таньж мэдэх” (KYC)²¹ бодлогын хүрээнд банк болон банк бус санхүүгийн байгууллагууд үйлчлүүлэгчдийнхээ хэн болохыг таньж мэдэх, баталгаажуулах үүрэгтэй бөгөөд ингэснээр санхүүгийн системийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлж болохоос гадна тухай бүр гүйлгээг хянаж, сэжигтэй үйл ажиллагааг эрх бүхий байгууллагад мэдээлэх үүрэг хүлээдэг. Харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ нь дотоодын хэрэглэгч нарын эрсдлийг үнэлж, хяналт тавихад үр дүнтэй боловч дутагдалтай тал бас бий. Тухайлбал, хуулийн зохицуулалт сул, хэрэгжилт муу, хяналт байхгүйн улмаас үүсгэн байгуулсан хуурамч

²¹ Know Your Customer? “Know Your Client (KYC) is a standard in the investment industry that ensures advisors can verify a client’s identity and know their client’s investment knowledge and financial profile”.

Three components of KYC include the customer identification program (CIP), imposed under the USA PATRIOT Act in 2001, customer due diligence (CDD), and ongoing monitoring or enhanced due diligence (EDD) of a customer’s account once it is established.

компаниудаар дамжуулан хууль бус хөрөнгийг нуух, тэдгээрээр дамжуулан хууль бус хөрөнгийг оруулж ирүүлэх эрсдэлтэй байдаг.

Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ)²² 2017 онд Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хийсэн харилцан үнэлгээний тайланд банкны үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.²³

Үүнтэй холбогдуулан банкны салбарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа бөгөөд үүний хүрээнд өөрийн харилцагч, тэдгээрт үзүүлж байгаа үйлчилгээ, бүтээгдэхүүний төрлийг эрсдэлээр ангилж, эрсдэлийг бууруулах тодорхой ажлуудыг зохион байгуулж эхэлсэн байна. Тухайлбал Засгийн газраас 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх “Үндэсний хөтөлбөр”²⁴-ийг боловсруулж баталсан ба түүнээс хойш ажлын үр дүн дахин сайжруулах шаардлагатай гэж үзэж 2022 онд шинэчлэн баталсан байна. Мөн үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө”²⁵, “Ази, номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” зэргийг боловсруулан баталсан байна.

Түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх, ФАТФ-ын 2016-2017 оны харилцан үнэлгээний техник хэрэгжилтийн үр дүнтэй байдлын үнэлгээг хангах үүднээс Ерөнхий сайдын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 70 дугаартай захирамжийн дагуу “Үндэсний зөвлөл”-ийг, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2007 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 160 дугаартай тушаалаар Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий “Хамтын ажиллагааны зөвлөл”-г тус тус байгуулсан ба тэдгээрийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг хэд хэдэн удаа буюу 2014, 2017, 2019 онуудад тус тус шинэчлэн баталж байсан.

Мөн “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй

²² The Asia/Pacific Group on Money Laundering (APG), <https://apgml.org/>

²³ Anti-money laundering and counter-terrorist financing measures Mongolia (Mutual Evaluation Report), <https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/fsrb-mer/Mongolia%20MER%202017%20-%20published%20version.pdf>

²⁴ National Strategy for anti-money laundering and countering financing of terrorism, https://www.mongolbank.mn/file/files/documents/cma/0905law2_e.pdf

²⁵ Action Plan for recommendations of the Asia-Pacific group on Money Laundering, https://www.mongolbank.mn/file/files/documents/cma/0905law3_e.pdf

тэмцэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих болон хуулийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зорилгоор “Зөрчлийн тухай хууль”-ийн 11.29 дүгээр зүйлд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчилд тооцон хуульчилсан нь тодорхой түвшинд ахиц дэвшил гарсан байна.

Б. Банкны өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжилт

2024 оны байдлаар Монгол Улсын банкны салбарт нийт 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Үүнд том 3, дунд 3, жижиг 6 банкууд багтаж байна. Банкны салбар нь санхүүгийн системийн 90 хувийг дангаар бүрдүүлдэг бол, үүнд хамаарах системд нөлөө бүхий 5 банк салбарын нийт активын 85 хувийг бүрдүүлж байна. Банкны салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглан гэмт хэргийн орлогыг өөрсдөөсөө холтгох, ул мөрийг нь баллах, хууль ёсны мэт болгох боломжтойгоос гадна гэмт хэргийн орлогоор банкинд хувь эзэмших, банк байгуулах болон гэмт этгээдүүд банкны удирдлагад нэвтрэн орж хууль бус үйл ажиллагаа явуулах эрсдэлтэй.

Сүүлийн жилүүдэд банкны салбар асар хурдтайгаар өөрчлөгдөж байна. Тэр дундаа сүүлийн 2 жил системийн нөлөө бүхий банкнууд хувьцаагаа олон нийтэд арилжаалах замаар өөрийн хөрөнгийг 487 тэр бум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Мөн сүүлийн 5 жилийн хугацаанд банкны салбар үр ашигтай ажиллаж, технологийн шинэчлэл болон бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлүүдийг нэмэгдүүлсээр байна. Хиймэл оюун ухаанд тулгуурлан харилцагчийн төлөв, үйл хөдлөлийг судлаж санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг илүү оновчтой болгож байна. Түүнчлэн хиймэл оюун ухааныг банкны дотоод үйл ажиллагааг сайжруулахад ашиглаж бүтээмж, үр ашгийг дээшлүүлэхэд түгээмэл байдлаар хэрэглэж байгаа нь банкны салбарыг төсөөлснөөс ч хурдан өөрчилж байна. Иймд дэлхийн жишиг, дотоодын эдийн засгийн байдал, хууль эрх зүйн өөрчлөлтийг сайтар судалж өөрийн онцлогт тохирсон өөрчлөлтийг хийхдээ мөнгө угаах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, илрүүлэх талаар арга хэмжээг тусгах нь зүйтэй.

Банк бус санхүүгийн байгууллагын эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, үр дүн

А. Банк бус санхүүгийн байгууллагын эрх зүйн зохицуулалт.

Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаанд болон түүнтэй тэмцэхэд банк бус санхүүгийн байгууллагын оролцоо ихээхэн чухал ач холбогдолтой байна. Учир нь Монгол Улсад санхүүгийн салбарт мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх өндөр эрсдэлтэй гэх бөгөөд түүн дотроо “ББСБ-ууд тооны хувьд олон, газар зүйн байршлын хувьд өргөн тархсан тул МУТС эрсдэл нь банкны бус сектор дахь бусад СБ-уудтай харьцуулахад илүү өндөр...

²⁶ байна гэж үзсэн байна.

Банк бус санхүүгийн байгууллагыг Компанийн тухай хуулийн 13, 18 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэх, хувьцаа гаргах, хувьцааны захиалга авах аргаар болон нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх зэрэг өөрчлөн байгуулах замаар, хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулж болдог.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар бүлэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсны дараагаар үйл ажиллагаа явуулна.

Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажиллагаанд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-д зааснаар эх банкинд хувь нийлүүлэх хөрөнгө нь хууль ёсны үйл ажиллагаанаас бий болсон хөрөнгө болохыг нотлох хангалттай баримт бичиг бүрдүүлсэн эсэх, банк байгуулах нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай аливаа байдлаар холбоотой эсэх, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх эсэх зэрэг шаардлагыг шалгасны үндсэн дээр Монгол банкнаас олгож байхад банк бус санхүүгийн байгууллага байгуулахад дээрх шалгуурыг шалгаж үзэхгүй байгаа нь учир дутагдалтай байна. Энэ нь банкыг үүсгэн байгуулахаас эхлэн мөнгө угаах хяналтыг сайжруулсан боловч үнэн хэрэгтэй банкнаас илүү эрсдэлтэй байгаа салбарыг орхигдуулахаас гадна үйл ажиллагаанд нь хяналт тавих эрх зүйн тогтолцоо хүртэл дутмаг болох нь харагдаж байна.

Банк бус санхүүгийн байгууллагад тавих хяналт, шалгалтын талаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар бүлэгт тусгасан хэдий ч үүсгэн байгуулах, зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь дан ганц хяналт тавих боломжтой байдлаар хуульд тусгасан нь хөндлөнгийн ямар нэгэн хяналт шалгалтын эрх зүйн орчинд бүрдээгүй, мөнгө угаах үйл ажиллагаанд банк бус санхүүгийн байгууллага болон түүний ажилтан нөлөөлөл бүхий этгээд хооронд үгсэн тохиролцох, хянах, шалгагч субъект хүртэл оролцоо бүрдэх боломжтой байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.6-т “санхүүгийн үйлчилгээний зөвшөөрөл эзэмшигч мөнгө угаах болон

²⁶ Anti-money laundering and counter-terrorist financing measures Mongolia (Mutual Evaluation Report), 17 дахь тал, <https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/fsr-mer/Mongolia%20MER%202017%20-%20published%20version.pdf>

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх хууль тогтоомжийг сахин биелүүлэх” үүрэгтэй талаар, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлд мөн дээрх үүргийг сахин биелүүлэх талаар тодорхойлон хуульчилснаас өөрөөр нарийн тодорхой зохицуулалтыг тусгаж өгөөгүй байна.

Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй бол зөрчлийн шинжээс хамааран Зөрчлийн тухай хуульд хариуцлага хүлээлгэх талаар заасан нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд буруутай этгээдийг тодорхой хэмжээнд хариуцлагажуулсан байна.

Банк бус санхүүгийн байгууллага нь тусгай зөвшөөрөл авснаас эхлэн мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой үйл ажиллагааг мэдээлэх үүрэгтэй этгээд болох бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд зааснаар “Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг баталж, эрх бүхий зохицуулагч байгууллагадаа бүртгүүлэх шаардлагатай. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөргэдэг нь “мэдээлэх үүрэгтэй этгээдийн МУТСТ чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх дотоод журам, дүрмийн цогц хөтөлбөр”²⁷ юм. Дотоод хяналтын хөтөлбөр нь хууль тогтоомжийг мөрдөхөөс гадна мөнгө угаах эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж юм. Түүнчлэн хуулийн хэрэгжилт хангуулахаар томилогдсон ажилтан нь тухай бүр мэдээ, тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх ба мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлын тайланг дотооддоо танилцуулдаг, мөн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх холбоотой үйл ажиллагааны зохих шаардлагыг тавьдаг байх хэрэгтэй юм. Үүний тулд үндэсний эрх зүйн орчин сайжруулах шаардлагатай.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг нь дан ганц банк бус санхүүгийн байгууллага бус түүнд зөвшөөрөл олгосон, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага буюу санхүүгийн зохицуулах хороо, төв банк, хууль сахиулах байгууллага, засгийн газар болон олон улсын чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран тэмцэх нь чухал ач холбогдолтой.

Иймд Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн

²⁷ Санхүүгийн зохицуулах хороо, “Банк бус санхүүгийн байгууллагын салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” гарын авлага УБ., 2021, 23 дахь тал

байгууллага 2017 онд Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хийсэн харилцан үнэлгээний тайланд²⁸ банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжүүдийг ирүүлсэн ба зөвлөмжийн хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийх зөвлөмжийг боловсруулж үндэсний хэмжээнд бүх салбаруудыг хамааруулан үзсэн байна.

Б. Банк бус санхүүгийн байгууллагын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжилт, үр дүн

2024 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 531 банк бус санхүүгийн байгууллага байгаа нь өмнөх оны мөн үеэс 17 буюу 3.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр банк бус санхүүгийн байгууллагуудын 95 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 24, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5, финтек зээлийн үйлчилгээ үзүүлж байгаа 50 банк бус санхүүгийн байгууллагууд байна.

2024 оны I улирлын байдлаар 15 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 13 банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 7 банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 9 банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Банк бус санхүүгийн байгууллагууд ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн жилүүдэд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр (146 ББСБ) ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын бусдаас татан төвлөрүүлж буй хөрөнгийн хэмжээ нэмэгдэж байгаа нь бусдын хөрөнгийг эрсдэлд оруулах, хууль бус хөрөнгө татан төвлөрүүлэх улмаар салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд эх үүсвэр татан төвлөрүүлсэн ББСБ-уудад тавигдах хяналт, зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20

²⁸ Anti-money laundering and counter-terrorist financing measures Mongolia (Mutual Evaluation Report), <https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/fsrb-mer/Mongolia%20MER%202017%20-%20published%20version.pdf>

сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 76 ББСБ, 3,708 удаагийн тохиолдлоор, 470.3 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ” гэж заасны дагуу нэр бүхий 4 ББСБ, 199 удаагийн тохиолдлоор, 2.1 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.²⁹

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд банк, банк бус санхүүгийн байгууллагын оролцоо түүнийг олон улсын жишигт нийцүүлэх асуудал

А. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд банк, банк бус санхүүгийн байгууллагын оролцоо

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь хувийн болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, нэмэгдүүлэх, тэдгээрийн харилцан хамаарлын тогтолцоо дахь үйл ажиллагаа чухал байдаг. Иймд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд банк болон банк бус санхүүгийн бусад байгууллага ямар шинэ хөгжлийг ажиглаж байна вэ?, Гэмт хэргийг ямар шинэ арга хэрэглэж үйлдэж байна вэ?, Ямар улс орнуудад шинэ хамгаалалтын системийг нэвтрүүлж байна вэ? гэх зэрэг асуулт мэт бодлогын хүрээний цогц үйл ажиллагааг төрийн байгууллагууд судлаж, түүнийг зураглаж, хурдан хариу үйлдэл үзүүлж, үндэсний эрх зүйн орчинд суурилуулснаар хамтын ажиллагаа бүрдэх ёстой. Ингэснээр банк болон банк бус санхүүгийн байгууллагын мөнгө угаахтай тэмцэхэд, урьдчилан сэргийлэхэд, илрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг гэдгийг ойлгуулах явдал юм.

Нэр хүндийн үүднээс авч үзвэл банк, банк бус санхүүгийн бусад байгууллага мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой байх нь бизнесийн итгэлийг алдагдуулж, үйлчлүүлэгчдийг хадгалах болон ирээдүйн түншлэлд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал: Хэрэглэгчдийн талаас илүү хувь нь одоогийн банк нь мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд банкаа солих, дахин үйлчлүүлэхгүй байх зэрэг эрсдэл байдаг тул банк бол мөнгө угаахтай тэмцэхэд тэдний оролцоо чухал байдаг.

²⁹ Банк бус санхүүгийн байгууллагын газар “Банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга”, УБ., 2024, 8 дахь тал

Харин ёс суртахууны хувьд, мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийг үл тоомсорлодог бизнесүүд өөрсдийн үйл ажиллагаандаа аюул учруулаад зогсохгүй гэмт хэрэгтнүүдэд гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг угаах боломжийг олгосноор хохирогчдын тоог нэмэгдүүлэх болон өөрийн улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж байдаг.

Иймд банк болон банк санхүүгийн бусад байгууллагын бизнесүүд мөнгө угаахтай тэмцэх хатуу тогтолцоог бий болгосноор эдгээр хууль бус урсгалыг таслан зогсоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Дагаж мөрдөх хатуу арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээс эхлээд биометрийн мэдээлэл зэрэг шинэ технологиудыг нэвтрүүлэх зэргээр байнга хөгжиж байна.

Түүнчлэн банк, болон банк бус санхүүгийн бусад байгууллагын тусламжтайгаар зарим улс орнууд үндэсний эрх зүйн тогтолцоогоо сайжруулж, бүрдүүлж, бэхжүүлэхэд туслалцаа авч байна. Үүний нэг илрэл нь Замбийн Банкны ерөнхийлөгч Доктор Калев М Фундангагийн зохион байгуулсан семинарт “Мөнгө угаахтай тэмцэхэд банкны салбарын үүрэг” илгэлдээ “Мөнгө угаахыг хориглох, урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд сан байгуулж, Замбийн санхүүгийн системийг бохир мөнгө угаах газар болгон ашиглахаас сэргийлэх болно, энэ нь бидний хүн нэг бүрд сорилт болж байна иймээс банкны салбарын хувьд үүнийг хангах нь тулгамдсан асуудал, тэдний компанийн засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлагын тогтолцоог анхааралдаа авах үүднээс шинэчлэн боловсруулж байна, Замбийн Банкны хувьд технологи, даяарчлалыг хүлээн зөвшөөч шинэчлэхийг хүлээн зөвшөөрөх нь бидний сорилт юм, мөнгө угаагчид гэмт хэрэг үйлдэж, нуун далдлах шинэ арга техникийг судлах байгаагаас үзэхэд биднээс илүү сонор сэрэмжтэй, эрч хүчтэй, авхаалжтай байхыг шаарддаж байна, түүнчлэн банк санхүүгийн салбарын хүрээнд бүрэн хамтын ажиллагаа, зохицуулалтыг хэрэгжүүлэх нь чухал байна”³⁰ гэжээ.

Банк, болон банк бус санхүүгийн бусад байгууллагууд нь мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхийн тулд үйлчлүүлэгчийн зохих шалгалт, тодорхой гүйлгээнд хяналт тавих, гүйлгээ, гүйлгээ хийж буй харилцагчийн мэдээллийг цуглуулах, хадгалах, илгээх, зэргээс гадна мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр боловсруулах, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаар хэлэлцэх тайлагнах, санал болгож буй бүтээгдэхүүн, мөнгөнд өртөх эрсдэлийг

³⁰ Caleb M Fundanga: The role of the banking sector in combating money Laundering, (A paper presented by Dr Caleb M Fundanga, Governor of the Bank of Zambia, at a seminar organised by the C and N Centre for Advanced International Studies, Lusaka, Zambia, 23 January 2003., <https://www.bis.org/review/r030212f.pdf>

үнэлэх зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой байдаг байна. Энэ нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүхэл бүтэн тогтолцоог бэхжүүлэх ажиллагаа байж болно. Тухайлбал Македон Улсын доктор Светлана Николоска-н “Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтолцоонд банкуудын гүйцэтгэх үүрэг” бүтээлд “...банкууд үйлчлүүлэгчдийнхээ талаар энгийн бөгөөд хүчирхэг дүн шинжилгээ хийх ёстой, банкны хувьд мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх талаар анхаарал хандуулахгүй бол бизнесийн харилцаанд орж чадалгүй дуусгавар болох болно”³¹ гэж дүгнэсэн байна.

Б. Олон улсын жишигт нийцүүлэх асуудал.

1. Банк болон банк бус санхүүгийн бусад байгууллага нь олон улсын жишигт нийцсэн стратегийн хяналт ба эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлэх:

Мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй стратеги нь мөнгө угаах гэмт хэргийн эмзэг байдлыг тодорхойлохын тулд банкны бүх үйл ажиллагааг цогцоор нь үнэлэхээс эхэлдэг. Энэхүү мөнгө угаахтай тэмцэх стратегийн хяналт бүхий бодлого нь банкинд тулгарч буй эрсдэлийн түвшинд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулдаг явдал юм.

а) Байгууллагын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ: Банкууд мөнгө угаах гэмт хэрэгт хамгийн өртөмтгий байгаа газруудаа тодорхойлохын тулд үйл ажиллагааныхаа бүх салбарт бүрэн дүн шинжилгээ хийдэг. Үүнд бүтээгдэхүүний нэр төрөл, хэрэглэгчийн хүн ам зүй, гүйлгээний төрөл, газарзүйн эрсдлийг үнэлэх зэрэг багтана.

б) Мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог тохируулах: Эдгээр эрсдлийн үнэлгээнд үндэслэн банкууд үйл ажиллагааныхаа янз бүрийн салбарт тодорхойлсон тодорхой эрсдэлүүдийг шийдвэрлэх тусгайлсан мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог боловсруулдаг. Энэхүү зорилготой арга нь нөөцийг үр ашигтай хуваарилж, хяналтыг эрсдэлийн түвшинд пропорциональ байлгах боломжийг олгодог.

в) Загварын эрсдэлийн менежмент: Эрсдэлийн удирдлагын загвар тогтолцоог нэгтгэх нь гүйлгээний хяналтын систем, хэрэглэгчийн эрсдэлийн үнэлгээний хөтөлбөр зэрэг мөнгө угаахтай тэмцэх загваруудыг үр дүнтэй ашиглахад маш чухал юм. Банкууд эдгээр хэрэгслүүдийг хянах зорилготой эрсдэлээ үр дүнтэй удирдахын тулд загвар боловсруулах, баталгаажуулах, засаглалыг багтаасан бүтэцлэгдсэн аргачлалыг баримтлах төлөвтэй байна.

³¹ Svetlana Nikoloska , Phd, “Role of banks as entity in the system for prevention of money laundering in the Macedonia” Procedia - Social and Behavioral Sciences Volume 44, 2012, Pages 453-459

2. Олон улсын жишигийн дагуу мөнгө угаахтай тэмцэх хяналтын ажилтанг бүрдүүлэх:

Банк болон банк бус санхүүгийн бусад байгууллагууд мөнгө угаахтай тэмцэх хяналтын чиг үүрэг бүхий ажилтнуудыг шаардлагатай туршлага, эрх мэдэлтэй ахлах ажилтнаар томилдог. Эдгээр албан тушаалтнууд нь мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр гаргасан дагаж мөрдөх хөтөлбөрийг бүхэлд нь хянаж, санхүүгийн зохицуулагчидтай харилцах чухал цэг болдог. Тэд мөнгө угаахтай тэмцэх стратегийн бүх элементүүдийг үр дүнтэй хэрэгжүүлж, банк болон банк бус санхүүгийн бусад байгууллагууд нь мөнгө угаахтай тэмцэхтэй холбоотой бүх дүрэм журмыг дагаж мөрддөг эсэхийг баталгаажуулдаг.

3. Олон улсын жишигт нийцсэн технологийн интеграци хийх тухай:

Мөнгө угаах гэмт хэргийн нарийн тактикуудаас түрүүлэхийн тулд банкууд мөнгө угаахтай тэмцэх стратегидээ дэвшилтэт технологиудыг байнга нэгтгэж нэвтрүүлэх шаардлагатай. Энэ нь банк болон банк бус санхүүгийн бусад байгууллагууд хууль тогтоомжийг дагаж мөрдөх үйл явцыг хялбаршуулахад зогсохгүй санхүүгийн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үнэн зөв, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлдэг.

а) Хиймэл оюун ухаан ба машинд сургалт³² (Artificial Intelligence /AI/ and Machine Learning): Хиймэл оюун ухаан суурилсан өндөр хурдны машин сургалтын алгоритмуудыг асар их хэмжээний гүйлгээний өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд ашигладаг. Эдгээр технологи нь хүний шинжээчдийн алдаж болзошгүй хэв маяг, гажуудлыг илрүүлж, мөнгө угаах үйл ажиллагааг илүү нарийвчлалтай урьдчилан таамаглаж, тодорхойлох боломжтой.

б) Блокчейн технологи (Blockchain Technology): Зарим банкууд гүйлгээний ил тод байдлыг сайжруулахын тулд блокчэйн ашиглах талаар судалж байна. Блокчэйн нь гүйлгээний өөрчлөлтийн бүртгэлийг бий болгож, хөрөнгийн гарал үүслийг хянахад хялбар болгож, мөнгө угаах боломжийг бууруулдаг. Тухайлбал: FICO³³-ийн Аналитик

³² Машин сургалт: Энэ нь өгөгдсөн ажлыг эсвэл мэдээллийг тусгай зааварчилгаа буюу програм ашиглалгүйгээр тодорхой алгоритмууд ба статистик загварууд ашиглан тухайн өгөгдөл ажлын нийтлэг шинж төлөв дээр үндэслэж судалдаг сурч авдаг ажиллагаа юм. Энэ нь хиймэл оюуны салбарын нэгэн дэд хэсэг болно. Машин сургалтын алгоритмууд нь даалгаврыг гүйцэтгэхийн тулд тодорхой програмчлалгүйгээр урьдчилан таамаглал, шийдвэр гаргахын тулд « сургалтын өгөгдөл » гэгддэг түүврийн өгөгдөл дээр суурилсан математик загварыг бий болгодог.

³³ FICO (Fair Isaac Corporation): Зээлийн үнэлгээний үйлчилгээнд төвлөрсөн, Монтана муж улсын Боземан хотод байрладаг Америкийн мэдээллийн аналитик

хариуцсан ахлах ажилтан, доктор Скотт Золди хэлэхдээ: “Блокчэйны хамгийн сэтгэл хөдөлгөм шинэ хэрэглээ бол Hyperledger Fabric зэрэг зөвшөөрөлтэй болон хувийн блокчейнүүдийг ашиглах явдал юм. Энэ нь хяналттай хандалт, гүйлгээний харагдах байдал, энгийн зөвшилцлийн загваруудыг бий болгох боломжийг олгодог ба эдгээр хувийн блокчэйн нь уламжлалт нийтийн блокчэйнтэй харьцуулахад хяналт, хандалт, өргөтгөх боломжийн асуудлыг тэнцвэржүүлдэг бөгөөд банкууд блокчэйн технологийг ашиглахтай холбоотой зардал, үр ашгийг тэнцвэржүүлэхийн зэрэгцээ хүртээмж, зөвшилцөл, хамгаалалтад анхаарлаа хандуулдаг”³⁴ гэж хэлсэн байна.

с) Биометрийн баталгаажуулалт (Biometric Verification): Хэрэглэгчийн таних үйл явцыг сайжруулахын тулд банкууд биометрийг улам бүр ашиглаж байна. Энэхүү технологи нь хурууны хээ, нүүр царай таних зэрэг өвөрмөц онцлог шинж чанаруудыг ашиглан хэрэглэгчийн хувийн мэдээллийг баталгаажуулдаг бөгөөд энэ нь уламжлалт аргуудаас илүү найдвартай, залилан мэхлэлтэд өртөмтгий биш юм. Мөнгө угаахтай тэмцэх (AML) хүчин чармайлтад биометрийн технологийг нэвтрүүлэх нь санхүүгийн байгууллагууд дагаж мөрдөх хөтөлбөрийнхөө аюулгүй байдал, үр ашгийг дээшлүүлэх арга замуудад мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргаж байна. Биометр нь мөнгө угаахтай тэмцэх стратегийн олон давхаргат хандлагын чухал бүрэлдэхүүн хэсэг болох үйлчлүүлэгчийг таних, баталгаажуулах найдвартай аргыг өгдөг. Биометрийн таниулбар нь хувь хүн бүрт өвөрмөц бөгөөд хуурамчаар үйлдэх нь маш хэцүү тул харилцагчдыг данс нээлгэх, гүйлгээ хийх үед нь нарийн тодорхойлох үр дүнтэй хэрэгсэл болгодог.

d) Зохицуулалтын технологи (Regulatory Technology /RegTech/): RegTech шийдлүүд нь технологийн дагуу зохицуулалтын нийцлийг удирдахад ашиглагддаг. Эдгээр шийдлүүд нь банкуудад зохицуулалтын өөрчлөлтийн хурдацтай алхаж, дагаж мөрдөх үйл явцыг аль болох үр ашигтай, хамгийн сүүлийн үеийн болгоход тусалдаг.

4. Банк болон банк бус санхүүгийн бусад байгууллага нь олон улсын жишигт нийцсэн сургалт ба дагаж мөрдөх соёлыг бэхжүүлэх:

Тасралтгүй сургалт, хатуу дагаж мөрдөх соёл нь мөнгө угаахтай тэмцэх (AML) үр дүнтэй арга хэмжээг авч үлдэхэд амин чухал юм.

а) Банк болон банк бус санхүүгийн бусад байгууллага бүр

компани юм. Үүнийг 1956 онд Билл Фэйр, Эрл Исаак нар үүсгэн байгуулжээ. Тус компани 2020 оны санхүүгийн жилд 1.29 тэрбум долларын орлого олсон гэж мэдээлсэн байна.

³⁴ <https://fintechmagazine.com/articles/blockchain-technology-and-modern-banking-systems>

сургалтын хөтөлбөрийг боловсруулах: Тогтмол болон байнгын сургалт нь банкны бүх ажилчдыг сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хамгийн сүүлийн үеийн өөрчлөлт, аргачлалыг ойлгох чадвартай болгодог.

б) Албан хэрэг хөтлөлт ба баримтжуулалт: Үйлчлүүлэгчийг хүлээн авахаас эхлээд гүйлгээний хяналт, Сэжигтэй үйл ажиллагааны тайланг (СГТ) ирүүлэх, үйлчлүүлэгчийг элсүүлэхээс эхлээд гүйлгээний хяналт болон цаашилбал үр дүнтэй баримтжуулалт нь маш чухал юм. Энэхүү баримт бичиг нь банкны зохицуулалтын тайлан гаргах, аудит хийх тохиолдолд дэмждэг.

5. Банк болон банк бус санхүүгийн бусад байгууллага нь олон улсын жишигт нийцхүйц үйл ажиллагааны нарийвчилсан журамтай байх:

Мөнгө угаахтай тэмцэх (AML) арга хэмжээг хэрэгжүүлэх нь өдөр тутмын дагаж мөрдөх даалгавруудыг хариуцдаг үйл ажиллагааны тусгай горимуудыг агуулдаг:

а) Хэрэглэгчийн хувийн мэдээллийг баталгаажуулах (Customer Identity Verification): Мөнгө угаахтай тэмцэхэд нийцүүлэх үйл ажиллагааны арга хэмжээний чухал бүрэлдэхүүн хэсэг нь хэрэглэгчийн биеийн байцаалтыг нарийн шалгах явдал юм. Энэ үйл явц нь банкны харилцааг эхлүүлэх үед үйлчлүүлэгчээ мэдэх (KYC) журмыг хэрэгжүүлэхээс эхэлдэг. KYC нь засгийн газраас олгосон баримт бичгүүдийг ашиглан тэдний биеийн байцаалтыг баталгаажуулах, санхүүгийн түүхийг цуглуулах, харилцагчийн банктай хийх гэж буй бизнесийн харилцааны мөн чанар, зорилгыг ойлгох зэрэг шинэ үйлчлүүлэгчдийн талаарх чухал мэдээллийг цуглуулах явдал юм.

б) KYC (үйлчлүүлэгчээ таньж мэдэх)-ийн дараа үйлчлүүлэгчтэй холбоотой эрсдлийг цаашид үнэлэхийн тулд Customer Due Diligence (CDD-хэрэглэгчийн хяналт) процедурыг ашигладаг. Энэхүү гүн гүнзгий үнэлгээ нь мөнгө угаах болон холбогдох санхүүгийн гэмт хэргийн болзошгүй эрсдлийг тодорхойлохын тулд харилцагчийн үйл ажиллагаа, тэдний бизнесийн харилцаа, санхүүгийн профайлд дүн шинжилгээ хийдэг.

в) Хориг арга хэмжээний шалгалт (Sanctions Screening): Банк болон банк бус санхүүгийн бусад байгууллага хориглогдсон байгууллагуудтай бизнес хийхгүй байхын тулд үндэсний, олон улсын хориг арга хэмжээний жагсаалтаас харилцагчдыг шалгадаг.

д) Улс төрийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийг (Monitoring Politically Exposed Persons /PEPs/) хянах: Банк болон банк бус санхүүгийн

бусад байгууллага нь улс төрийн нөлөөлөлд өртсөн хүмүүст (PEPs) зохих шалгалтыг сайжруулж, үндэсний болон олон улсын хориг арга хэмжээний жагсаалтаас бүх харилцагчдыг шалгадаг. Энэ нь эрсдэл өндөртэй хувь хүн, аж ахуйн нэгжүүдээр дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд санамсаргүйгээр туслахгүй байхад тусалдаг.

6. Олон улсын жишигт нийцсэн хяналт ба тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

Тасралтгүй хяналт, цаг тухайд нь тайлагнах нь мөнгө угаахтай тэмцэх дагаж мөрдөх хөтөлбөрийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Гүйлгээний хяналтын системийг нэвтрүүлэх нь мөнгө угаах үйлдлийг илтгэж болох ер бусын эсвэл сэжигтэй гүйлгээний хэлбэрийг илрүүлэхэд ашиглагддаг. Банк болон банк бус санхүүгийн бусад байгууллага нь хориглогдсон эсвэл хориглогдсон байгууллагуудтай бизнес хийхгүй байхын тулд үндэсний болон олон улсын хориг арга хэмжээний жагсаалтаас харилцагчдыг шалгадаг бөгөөд санхүүгийн байгууллагууд эдгээр нарийвчилсан журмын даалгавруудыг стратегийн хяналттай нэгтгэснээр мөнгө ургаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үр дүнтэй удирдах боломжтой. Энэхүү иж бүрэн арга нь зохицуулалтын шаардлагыг хангахаас гадна санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, урт хугацаанд үйл ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэсэн банк болон банк бус санхүүгийн бусад байгууллагын үүрэг амлалтыг нэмэгдүүлэх боломжтой.

III. Дүгнэлт

Үндэсний эрх зүйн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх хамтын үйл ажиллагааны хүрээнд ФАТФ-ын зөвлөмжийн дагуу мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд улс орон бүр өөрийн бүс нутгийн онцлог, эдийн засаг, нийгмийн байдал зэргийг харгалзан үзэж үндэсний эрх зүйн тогтолцоог бэхжүүлэхийг зорьж байна. Манай улсын хувьд энэ аргачлалын дагуу үндэсний эрх зүйн тогтолцооны гол эх сурвалж болох эрүүгийн хуульд хэд хэдэн удаа өөрчлөлт оруулсан боловч сүүлийн буюу 2015 оны өөрчлөлтөөр өмнөх гэмт хэргийн зохицуулалттай агуулгын хувьд ижил боловч суурь гэмт хэргийн талаар тодорхой зааж өгөөгүйгээс энэ төрлийн гэмт хэргийн үндсэн хууль зүйн шинжийг ойлгоогүй, тодорхойлж чадаагүй нь ахуйн хүрээний хийгээд бүхий л гэмт хэргийг хамруулахаар байна.

Өнөө үед банкууд мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Үнэн хэрэгтээ санхүүгийн байгууллагууд тэр дундаа банк, банк бус санхүүгийн байгууллага мөнгө угаах, терроризмыг

санхүүжүүлэхэд шууд бусаар хувь нэмэр оруулах хүсэл огт байхгүй. Санхүүгийн гэмт хэрэгтнүүд зөвхөн томоохон банкнуудыг онилдоггүй, жижиг, дунд банк бус санхүүгийн байгууллагууд ч мөн адил эмзэг бөгөөд санамсаргүйгээр мөнгө угаах суваг болж чаддаг. Тиймээс магадгүй тэдгээрийн сул тал нь (хяналт, шалгалт, зохицуулалт сул) мөнгө угаах гэмт хэргийг өөрийн мэдэлгүй хөнгөвчлөх боломжтой байдаг байна. Банк болон банк бус санхүүгийн бусад байгууллага нь бага үнийн дүнтэй гүйлгээний анхаарлыг татахгүй байх тохиргоо бүхий тандалтын системээр өндөр эрсдэлтэй эрх мэдэлтэй холбоотой үйл ажиллагаа гэх мэт хэвийн бус зан үйлийг илрүүлэх чадвартай байх ёстой. Тиймээс энэ нь бодит цаг хугацаанд, хуулийн үүргийн дагуу ажиллах алгоритм, хүний хяналтыг хэрэгжүүлэх явдал юм. Мөнгө угаах гэмт хэргийг ойлгохгүйгээр тэмцэх боломжгүй. Хамгийн боловсронгуй илрүүлэх систем ч боловсон хүчнийг хангалттай сургахгүйгээр үр дүнгүй байж болно. Ийм учраас мөнгө угаахтай холбоотой эрсдэлийн талаар ажилтнуудыг тогтвортой тасралтгүй сургах нь ач холбогдолтой.

Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх систем нь зөвхөн хууль ёсны үүрэг хариуцлага биш харин ёс зүй, арилжааны зайлшгүй шаардлага юм. Банк болон банк бус санхүүгийн бусад байгууллага эдгээр талыг үл тоомсорлож, өөрийн ашиг нэр хүндээ бодож хатуу хориг арга хэмжээг авч чадаагүйн эцэстээ бизнесээ алдах хүртэл эрсдэл байдаг. Хууль эрх зүйн болон зохицуулалтын үүргээ чандлан биелүүлэх нь зөвхөн хууль ёсны шаардлага биш, бөгөөд сайн засаглал, дэлхийн эдийн засгийн тогтолцооны бүрэн бүтэн байдалд хувь нэмэр оруулах ёс суртахууны болон арилжааны зайлшгүй шаардлага юм.

Санхүүгийн салбарт мөнгө угаахтай тэмцэх (AML) арга хэмжээ урьд өмнөхөөсөө илүү чухал болж байна. Санхүүгийн гэмт хэрэг улам бүр нарийсч буй эрин үед банкууд санхүүгийн системийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тулд сонор сэрэмжтэй байх банкны үйл ажиллагаанд мөнгө угаахтай тэмцэхийн практикийн ач холбогдлыг онцолж, зохицуулалтын стандартыг дагаж мөрдөх, санхүүгийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх явдал юм.

Стратегийн хяналт, эрсдэлийн үнэлгээнээс эхлээд биометрийн мэдээлэл, хиймэл оюун ухаан суурилсан машин сургалт, блокчейн зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нь банк болон банк бус санхүүгийн байгууллага нь мөнгө угаах бусад хууль бус санхүүгийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Банк болон банк бус санхүүгийн байгууллага нь мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаа нь дэлхийн стандарт, зохицуулалтын

шаардлагад нийцсэнээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээд зогсохгүй санхүүгийн системийг хамгаалах, харилцагчдынхаа итгэлийг хадгалах үүрэг хариуцлагаа биелүүлдэг.

Санал:

Дээрх дүгнэлтэд үндэслэн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор дараах саналыг дэвшүүлж байна.

1. Олон улсын стандартад заасан “суурь гэмт хэрэг” гэх нэршлийг хуульчилж суурь гэмт хэргийг ойлголт, хууль зүйн шинжийг зөвтгөх, үндэсний нийгэмд эдийн засгийн байдал, хэрэгцээ, шаардлагад нийцүүлж ахуйн гэмт хэргээс ялгах

2. Суурь гэмт хэрэгт “бүх ноцтой” гэмт хэргийг хамруулахаар заасан зөвлөмжийн дагуу Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэргийг тооцох

3. Санхүүгийн салбарт мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх өндөр эрсдэлтэй гэх бөгөөд түүн дотроо банк бус санхүүгийн байгууллага өндөр эрсдэлтэй байгаа нь зөвлөмж, хууль тогтоомжийн хэрэгжилт сул, хяналт бараг байхгүй тул эрх зүйн орчин бүрдүүлэх. Тухайлбал: Банк байгуулах банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлд банканд хувь нийлүүлэх хөрөнгийн эх үүсвэр хууль ёсны байх, мөнгө угаах үйл ажиллагаатай аливаа хэлбэрээр холбоотой эсэх, мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийг нэмэгдүүлэх эсэх шаардлагыг харгалзан үзэж төв банкнаас олгож байгаа бол банк бус санхүүгийн байгууллагыг байгуулахад Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны тухай хуульд зааснаар СЗХ-оос зөвшөөрөл олгохдоо мөнгө угаахтай холбоотой шаардлагыг эрх зүйн орчинд тусгаагүй бөгөөд тоон үзүүлэлтээр хэт их, хяналт сул байна. Банкны нэгэн ижил стандартыг мөрдүүлэх нь зүйтэй.

4. Зохицуулагч байгууллага хувьд (МБ, СМА, СЗХ) мөнгө угаах эрсдэлийн үнэлгээ хийхээс гадна банк болон банк бус санхүүгийн байгууллага дотооддоо эрсдэлийн үнэлгээ хийх үүргийг хууль эрх зүйн орчинд тусгах нарийвчилсан аргачлалыг тодорхойлж журамлаж, энэхүү дотоодын мөнгө угаах эрсдэлийн үнэлгээг бусад хөндлөнгийн байгууллагаар хийлгэх боломжийг хүртэл хуульчилж өгвөл зүйтэй.

5. Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ)-ээс хүргүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлан, мэдээллийг хэрхэн шийдвэрлүүлсэн талаар мэдээллийг холбогдох хуулийн байгууллагаас авч хамтран ажиллан мэдээлэл өгсөн ажилтанд үр

дүнгийн талаар буцааж мэдэгдэх үүргийг журмаар зохицуулах.

6. Олон улсын жишигт нийцсэн технологийн интеграци хийх, стратегийн хяналт, эрсдэлийн үнэлгээнээс эхлээд биометрийн мэдээлэл, хиймэл оюун ухаан ба машин сургалт, блокчейн технологи зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нь банк болон банк бус санхүүгийн байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад хууль бус санхүүгийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж буй явдал юм.

[Ном зүй]

- Ян Клабберс, Олон Улсын эрх зүй, УБ., 2022.
- Баярсайхан Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ., 2012.
- Монгол, Орос, Хятад, Герман, улсын эрүүгийн хууль, Орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл, УБ., 2021.
- Баатаржав Н. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн тусгай анги8 сурах бичиг. УБ., 2012.
- Галдаа Б. Монгол Улсын Эрүүгийн хууль ба гэмт хэргийн зүйлчлэл, УБ., 2012.
- Жанцан С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги), УБ., 2012.
- Энхболд Б., Гантулга С. Эрүүгийн эрх зүй тусгай анги, сурах бичиг, УБ., 2024.
- Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам, зааврын эмхэтгэл, УБ., 2016.
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны сургалтын гарын авлага, УБ., 2018.
- Мөнгө угаах гэмт хэрэг, гарын авлага, УБ., 2020.
- Эдийн засгийн гэмт хэрэг II, УБ., 2018.
- Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь, УБ., 2020.
- Олон улсын нийтийн эрх зүй, гарын авлага, УБ., 2007.
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнтэй тэмцэх асуудал, УБ., 2013.
- Банк бус санхүүгийн байгууллагын салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай гарын авлага УБ., 2021.
- Yusarina Mat Isa “Money Laundering Risk: From the Bankers’ and Regulators Perspectives”
- Caleb M Fundanga: The role of the banking sector in combating money Laundering, (A paper presented by Dr Caleb M Fundanga, Governor of the Bank of Zambia, at a seminar organized by the C and N Centre for Advanced International Studies, Lusaka, Zambia, 23 January 2003.
- Svetlana Nikoloska , Phd, “Role of banks as entity in the system for prevention of money laundering in the Macedonia” Procedia - Social and Behavioral Sciences Volume 44, 2012.
- Anti-money laundering and counter-terrorist financing measures Mongolia (Mutual Evaluation Report).
- United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances, 1988.

International standards on combating money laundering and The financing of terrorism & proliferation (The fatf recommendations), 2012-2025.

Монгол Улсын Үндсэн хууль

Эрүүгийн хууль 1986, 2002, 2015.

Зөрчлийн тухай хууль, 2017.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013.

Банкны тухай хууль, 2010.

Зөвшөөрлийн тухай хууль, 2022.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005.

Компанийн тухай хууль, 2011.

Төв банк /Монгол Банк/-ны тухай хууль, 1996.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, 2002.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn>

Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, www.shuukh.mn

Монгол Улсын Прокурорын ерөнхий газар, <https://prosecutor.mn/>

Цагдаагийн ерөний газар, <https://police.gov.mn/>

Монгол Улсын төв банк (Монгол банк), www.mongolbank.mn

Санхүүгийн зохицуулах хороо, <https://www.frc.mn/#/home>

МБ, Санхүүгийн мэдээллийн алба, <https://fiu.mongolbank.mn/mn/>

Банк бус санхүүгийн байгууллага, <https://gbcc.mn/>

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэдээллийн нэгдсэн систем, <https://www.amlcft.mn/legal>

United Nation, <https://www.un.org/en/>

World Bank group, <https://www.worldbank.org/ext/en/home>

The Financial Action Task Force (FATF), <https://www.fatf-gafi.org/en/home.html>

Asia/Pacific Group On Money Laundering, <https://apgml.org/>

Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн шийдвэрийн судалгаа” цуврал 16, УБ., 2024.

Монгол банк, 2019 оны жилийн тайлан,

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ, УБ., 2020.

Санхүүгийн мэдээллийн алба (СМА), 2021 оны үйл ажиллагааны тайлан.

Монгол банк “Хялбаршуулсан хэлбэрээр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмж” УБ., 2024.

Монгол банк, “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан” №18, УБ., 2024.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалын хавсралт.

Банк бус санхүүгийн байгууллагын газар “Банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга”, УБ., 2024.

Санхүүгийн мэдээллийн албаны танилцуулга, 2024.

[Abstract]

**A Comparative Study of the Participation of Banks
and Financial Institutions in Combating Money
Laundering and its Legal Regulation**

Jargalsaikhan Uyasakh

Bachelor of laws (LL.B.)

Ulaanbaatar, Mongolia

In recent years, the evolving nature, characteristics, and methods of money laundering crimes have become more specialized, negatively impacting various sectors of society, including the global economy, banking, finance, and business. As a result, international and regional organizations, along with national authorities, have been actively working together to establish a unified standard for combating money laundering. The risk of money laundering crimes increases depending on the terms and conditions of the products and services offered by financial institutions. In particular, non-bank financial institutions, which are numerous in number and widely dispersed geographically, face a higher risk of money laundering compared to other financial institutions in the non-bank sector. Therefore, the involvement of both banks and non-bank financial institutions in combating money laundering, along with the legal regulations that ensure their coordination, must be aligned with future international trends and improved to establish effective countermeasures.

[Keywords]

Money laundering, predicate crimes, international standards, international legal systems, national legal systems, banks, non-bank financial institutions, risk assessment, suspicious transactions, know your customer, monitoring operations, regular training, artificial intelligence, machine learning, new technologies.